

“ҮХЭР ЖИЛИЙН ҮЙМЭЭНИЙ ГЭРЭЛ БА СҮҮДЭР ” ХЭМЭЭХ ЗОХИОЛЫН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ, ШҮҮМЖ

3. Лонжид

(Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн Тэнхимийн проф.
доктор)

“Үхэр жилийн үймээний гэрэл ба сүүдэр” хэмээх энэ номыг зохиогч БНХАУ-ын Өвөр Монголын Их сургуулийн орчин үеийн түүхийн хүрээлэнгийн захирал түүхийн шинжлэх ухааны доктор Өргэдэй Тайван 1963 онд Өвөр монголын Жалайд хошууны Баян-Улаан суманд оточ Буянхэшигийн гуравдахь хөвгүүн болон төрж, 1985 онд Өвөр Монголын Их Сургуульд элсэн суралцаж, хэл бичгийн мэргэжилтэн болон төгсөж, улмаар 1995-2003 онд Японы Киото Фү-гийн их сургуулийн Дорнод Азийн орон бүсийн шинжилгээний хүрээлэнгийн докторантурт суралцаж 1999 онд түүхийн ухааны дэд доктор, 2002 онд түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан байна. Тэрбээр "Богд хааны засгийн газар ба Өвөр Монгол орны улс төр" зэрэг эрдэм шинжилгээний нэг сэдэвт зохиол, хориод өгүүлэл хэвлүүлсэн бөгөөд цаашид Монголын түүх, алс дорнод дахь олон улын харилцаа, түүхийн сурвалж судлал зэрэг эрдмийн чиглэлээр Монголын түүхнээ холбогдох сурвалжийг олж мэдээлэн судалгааны эргэлтэд оруулж, Монгол судлалаар даацтай бүтээл туурвиж, Монголын эх түүхийн шинжилгээнд дорвитой хувь нэмэр оруулах нь дамжиггүйг энэ дашрамд зориуд тэмдэглэе.

Өргэдэй Тайвангийн "Үхэр жилийн үймээний гэрэл ба сүүдэр" энэхүү зохиол нь ХХ зууны эхэн үеийн Монголын түүхийн судалгаанд гүнзгийрүүлэн судлах шаардлагатай хэд хэдэн асуудал хөндөж шинэлэг санаа дэвшүүлсэн нь нэн үнэлүүштэй. Иймээс би уул бүтээлд авч үзсэн гурван сэдвийн тухай уншигч эрхэм абугайд өргөн танилцуулахын сацуу өөрийн бодол эргэцүүлээ хуваалцахыг хичээлээ.

НЭГ. 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалд Өвөрлөгч ноёд хэрхэн хандсан мухай

1911 оны өвөл Их Хүрээнд байгуулсан Халхын Хүрээний бүх хэргийг түр ерөнхийлэн захиран шийтгэх газар Богд Жибзундамба хутагтын зарлиг болгосны дагуу Монгол улс Чин гүрний эрхцэлээс ангижирч төрийн бүрэн тусгаар тогтнолоо сэргээн тунхаглахаар бэлтгэж байгаагаа Өвөр Монголын зургаан чуулган, Хөх Хотын Түмэдийн зүүн баруун засаг, Хар Мөрөнгийн Их Мянган, Өөлэдийн засаг, Алаша ван, Дариганга хуучин, шинэ Баргын олон хошууны бүгдийн дарга нарын газар тусгай элч довтолгон хүргүүлж" улс байгуулахад эрхгүй цэрэг хэрэглэх"- ээс гадна " зах хязгаарын сэргийлэн батлах нь чухлын тул олон хошуудын цэргийг дайчилж нэгэнтэйгүүр өөр улсын харьяат нутгийн чухал судал зам бүхий газруудад цэрэг суулгаж сэргийлүүлэн газар орныг ариун чанга болгосугай"(Магсаржав Н. 1994.11) хэмээн мэдэгдэхэд Өвөрлөгч ноёдын олонхи нь дэмжиж Богд эзэн хаантны хүнд хэшиг гүн соёлд дуртайя дагаар орохоо илэрхийлсэн бөгөөд энэ тухай Монголын түүхчид янзбүрийн байдлаар судалсан билээ. Гэвч үүнийг эх сурвалжид тулгуурлан тайлбарласан зохиогч цөөхөн юм. Харин Өргэдэй Тайван энэ тухай нилээд тодорхой өгүүлжээ. Тухйлбал Өвөрлөгч ноёд дээрх бичгийг хүлээн авч танилцсаны дараа бинт ван Гончигсүрэнгийн удирдлагын

дор Хорчин зүүн гарын хойд хошууны бодлогот чин ван Амарлингуй гүн Насан-Арвижих, Хорчин зүүн гарын дундад хошууны Зоригт чин ван Цэвээндонров, хорчин баруун гарын Өмнөд хошууны засагт Чин ван Удай, Хорчин баруун гарын хойд хошууны улсын түшээт гүн Рашминжүүр Найман хошууны Жүн ван Сүжигбаатар нар" монгол ван гүнгүүдийн нууц хуралдаан"(Тайван 147-148) хийж Өвөр Монголын цаашдын хувь заяаны тухай хэлэлцээд " Монголын тусгаар вант (хаант 3.Л) улс байгуулахаар санал нэгдсэн байна"(Тайван 148) гэдгийг Өргэдэй Тайван дурджээ. Ийнхүү өвөрлөгч ноёдын олонхи нь бүх монголчууд нэгдэж нэг улс болохыг дуртайя зөвшөөрч Монгол улсын харьят болон дагаар орцгоохоо албан ёсоор илэрхийлсэнийг Богд хаантан зарлиг буулган ёсоор болгосон төдийгүй хожим нь хэд хэдэн ямны дэд сайд эрхэлсэн түшмэлээр өвөрлөгч ноёдыг томилон алба хашуулсан юм.

Өвөрлөгч ноёдын цөөвтөр хэсэг нь Монгол улсын харьялалд орохоос цааргалж байсан тухай Зохиогч энэ бүтээлдээ хураангуй өгүүлсэн байна. Түүний бичсэнээс үзвэл 1912 оны гуравдугаар сард Сун Ят сен ДИУ- ын түр ерөнхийлөгчөөс огцорсны дараа Юань Шин кай түүний оронд томилогдож тус улсад дотоодын хямрал хурцадсан үед Харчин ван Гүнсэньоров Жирим, Зуу- Уд Зост гурван чуулганы төлөөлөгчидтэй Улаанхадад уулзаж Өвөр Монголын тусгаар тогтнох хөдөлгөөний тухай хэлэлцсэн байна. Үүнийхээ дараа Гүнсэньоров Японы Квашима зэрэг хүмүүстэй ярилцаж дэмжлэг авахаар тохирсон аж. Энэ явдалд Бавуужав ч бас оролцжээ. Гүнсэньоровын хатан нь Чин улсын их сайд Сү Чин вангийн дүү байсан бөгөөд ер нь 1911 оноос өмнө өвөрлөгчдөөс олон хүн Манжийн ихэс дээдэстэй худ ураг бололцсон байв. Тиймээс ч тэдний зарим нь Чингийн төрийг дахин сэргээхийг эрмэлзэж байсан аж. Тэд Өвөр Монгол бол угаасаа хятадын газар нутаг бус учир Цагаагчин гахай жилийн хувьсгалын дараа ДИУ- ыг дагах ёсгүй. Гэхдээ хятадаас тусгаар байхад хүрвэл Орос, Япон хоёрын аль нэгийг нь дэмжлэгт тулгуурлах ёстой хэмээсэн байр суурьтай байв. Япон улс Орос Хятадын дунд орших Ар Өвөр Монголын улс төрийн байдлыг байнга хянахын тулд ван Гүнсэньоровын орд өргөөг түшиглэх болжээ. Үүнээс бүр өмнө 1904 оноос эхлэн Гүнсэньоровын"ордон нь Японы тагнуулын ажиллагааны чухал төв болж"(Тайван 150) байсан гэж энэхүү зохиолд дурджээ. Үүнийг нэмэн тодруулж хэлэхэд 1911 оны эцсээр монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан тэр цагаас эхлэн Хаант орос Улс Монголд ялангуяа Гадаад Монголд нөлөөгөө гүнзгийрүүлэхийн төлөө онцгой анхаарсан бол ДИУ Гадаад Монголыг өөрийнхөө шууд харьяалалд байлгах бодлого тууштай баримталж байв. Өөрөөр хэлбэл Монголын өмнө хойд хоёр их гүрэн монголын тухайд онцгой анхаарч байсан билээ. Гэтэл Япон улс 1907 онд Манж гүрний зүүн хойд хэсэгт нөлөөгөө тогтоохыг Хаант Оросоор зөвшөөрүүлсэнээ улам лавшруулахын тулд 1911 оны сүүлчээс эхлэн Өвөр Монгол, Манжуурт нөлөөгөө гүнзгийрүүлэхийг нэн хичээж байлаа.

Ингэж 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал ялсны дараа Хаант Орос, ДИУ, Японы аль аль нь Монголын тухайд харилцан адилгүй бодлого баримталж байв. Харин Монголын төр засаг эдгээр гурван улсын аль алиных нь бодлогыг тууштай эсэргүүцэж бүх монголыг нэгтгэсэн бие даасан тусгаар улс байхыг хичээн энэ тухайгаа олон улсад албан ёсоор мэдэгдсэн байдаг. Гэтэл өвөрлөгч ноёдын зарим нь Гүнсэньоровыг дэмжиж Японы тусламжид дулдуйдан огт өөр зорилго хэрэгжүүлэхийг санаархах болжээ. Тиймээс ч 1912 оны нэгдүгээр сарын 22- нд Гүнсэньоров Японоос мөнгө зээлэх гэрээнд гарын үсэг зурж" Монголын ашиг тусыг хамгаалах ба Чин улсын хаант төрийн сэргээх үйл ажиллагаа"- ндаа зориулсан боловч энэ санаархал биелээгүй билээ. Өргэдэй Тайвангийн зохиолд ингэж өгүүлснийг эргэцүүлэхэд 1911 оны сүүлчээс эхлэн Өвөрлөгч ноёдын улс төрийн байр суурь хоёр чиглэлд хуваагдаж байжээ. Үүнд нэгдүгээрт Гончигсүрэн тэргүүтэй хэсэг ноёд Гадаад монголтой нэгдэж нэгэн улс болох, Хоёрдугаарт Гүнсэньоров тэргүүтэй ноёд Японы дэмжлэгтэйгээр Манжийн хаант төрийг сэргээж түүний бүрэлдэхүүнд багтахыг

хичээж байжээ. Энэхүү хоёр чиглэлийн аль аль нь монголчууд ДИУ-ын бүрэлдэхүүнд орох ёсгүй гэсэн ижил байр суурь хатуу баримталж байв.

Чухам үүний улмаас буюу бүх монголыг өөрийхөө нутаг дэвсгэрийн нэг хэсэг байлгах бодлого хэрэгжүүлэхийн тулд ДИУ Өвөр Монголд цэрэглэн халдах болсон байна хэмээх санаа Проф.Тайвангийн зохиолоос мэдэгдэж байна. Энэ дашрамд тэмдэглэхэд Гүнсээноров тэргүүтэй Японы тусламжид тулгуурлан Манжийн төрийг сэргээхийг хичээсэн өвөрлөгч ноёдын үйл ажиллагааг цаашид нилээд ултай судлууштай. Ийм судалгаа хийхэд Япон, Хятадын эрдэмтэд тун чухал үүрэгтэй нь мэдээж билээ.

Жич:энэ талын бүтээл туурвил хэвлэгдэж нийтийн хүртээл болсон байж магадгүй боловч бядуу би олж үзээгүй байж тун магадгүйг дашрамд дурдъя.

ХОЁР. 1913 оны Монгол Түвэбийн найрамдлын гэрээний тухай

Өргэдэй Тайвангийн энэхүү бүтээлд авч үзсэн бас нэг чухал зүйл бол 1913 оны эхээр Монгол Түвэбийн хооронд байгуулсан гэрээ юм. Энэ гэрээний тухай нилээд хүмүүс хөндөн тайлбарласаар ирснийг Зохиогч тэмдэглээд уул гэрээний талаар хоёр асуудал хөнджээ. Үүнд 1-рт Уг гэрээг байгуулсан огнооны тухай; хоёрдугаарт ер нь тийм гэрээ байгуулсан уу үгүй юу гэдэгт зарим хүн эргэлзэж байдаг тухай юм.

Өргэдэй Тайван 1934 онд түүхч Л. Дэндэвийн бүтээлд уул гэрээний тухай дурдсаныг эшлээд" тус гэрээг байгуулсан нь1913 оны нэгдүгээр сарын арван едөр олноо өргөгдсөн хоёрдугаар оны арванхоёр сарын гэж тэмдэглэж байна. Гэтэл 1982 онд хэвлэсэн "Монголын дөрөвний өдөр ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл—Барүмм бичгийн эмхмгэл" (Эмхтгэсэн А. Очир Г. Пүрэв) номд тэрхүү гэрээг 1913 оны хоёрдугаар сарын дөрөвний өдөр гэж бичсэн нь ташаарсан зүйл болох нь илтэд байна."(Тайван 74) гэжээ. Өргэдэй Тайвангийн энэ санал зөв боловч тэрээр үүнийхээ нотолгоог хэлээгүй байна. Тиймээс энэ талаар цухас өгүүлье. Эдүгээ манай улсын Гадаад Хэргийн Яамны Архивт бүрэн бүтнээр нь :

Монгол улсын олноо өргөгдсөний хоёпбугаар он

арванхоёр сарын шинийн дөрвөний өдөр

Түвэд улсын усан хулгана жилийн

гэж огноог тэмдэглэжээ. өөрөөр хэлбэл"Монгол улсын олноо өргөгдсөний хоёпбугаар он"ба"Түвэд улсын усан хулгана жилийн"гэж зэрэгцээ бичээд дараа нь "арванхоёр сарын шинийн дөрвөний өдөр" гэж тэмдэглэжээ.

Үүнээс үзвэл гэрээ байгуулсан хоёр улсын он, жилийг тус тусад нь бичсэн байх атлаа арван хоёр сарын шинийн дөрвөний өдөр гэж сар өдрийг дунд нь тэмдэглэсэн явдал бол Монгол албан бичгийн уламжлал баримтласных аж. Түүнээс бус аль нэг улсынх нь сар өдрийг бичихээ мартсных бишээ. Тэгэхээр олноо өргөгдсөний арванхоёр сарын шинийн дөрвөнийг Григорийн тоололд шилжүүлбэл А. Бямбажаргалын тооцоолсноор бол арвантай тохирч байна. Ингэхээр дээрхи гэрээнд гарын үсэг зурсан огноо нь 1913 оны нэгдүгээр сарын арван, арваннэгний өдрийн аль нэг нь байх ёстой. Энд яагаад хоёр өдөр (10,11)-ийн аль хэг гэж байна вэ гэвэл билгийн тооллыг Юлийн ба Григорийн тоололтой харьцуулахад заримдаа нэг өдрөөр зөрөх тохиолдол байдаг. Бодоход ингэж зөрөх учиргүй мэт. Гэвч астрофизикчид үүнийг сонирхдоггүй нь харамсалтай.

Түүхч Дэндэв абугай эдүгээ манай улсын ГХЯ-нд хадгалж буй эхийг зохиолдоо

ашигласан учраас 2 дугаар сарын 4 гэдгийг өөрийнхөө бүтээлд дурдсан бололтой. Дэндэвээс бусад судлаачид ГХЯ-нд хадгалж буй эхийг хараахан олж үзээгүй буюу эсвэл огноог нь тогтож ажиглаагүй бололтой. Энэүү гэрээний өөр нэгэн эх Үндэсний төв архивт байх бөгөөд гадар нүүрэнд нь "Монгол Түвэдийн гэрээ" хэмээн бичиж" Улсын номын сан" гэсэн тэмдэг дарсан үдээстэй бичгийн эхний хуудсанд" Нийслэл Хүрээний сонин сонсгол. Харбин хороонаа өргөн хүргүүлсэн ажиаму" хэмээх арванхоёр үг бичээд гарсан байна. Уул гэрээний төгсгөлд" Монгол Улсын усан хулгана жилийн өвлийн сүүл сарын шинийн гуравнаа монголын Нийслэл Хүрээнээ тогтоов" гэжээ. Үүнийг Л. Бямбажаргал В.В Цыбульский нарын тооцоололтой жишвэл 1913 оны нэгдүгээр сарын арван(Л. бямбажаргал 1912), арваннэгний өдөртэй тохирч байна (В.В.Цыбульский 361). Харин билгийн тооллоор бол ГХЯ-ны архивт буй эхэд бичсэн огнооноос нэг өдрийн өмнө байна. Энэ гэрээний бас нэгэн эх УТА-д хадгалагдаж буй бөгөөд түүний эх ноорогт "Монголын олноо өргөгдсөн хоёрдугаар оны арванхоёр сарын" гэж бичсэн боловч өдрийн тоог тэмдэглээгүй байна. Харин уул эх нооргийг сийрүүлсэн хуулбарт" Монголын олноо өргөгдсөний хоёрдугаар он арванхоёр сарын хорин еснөө Нийслэл Хүрээнээ хэлэлцсэн гэрээ бичиг" хэмээн огноог бүрэн тэмдэглэжээ. Энэхүү 29-ний өдрийг дээр дурдсан хоёр тооцоололтой харьцуулахад 1913 оны хоёрдугаар сарын дөрвөнтэй таарч байна. Өөрөөр хэлбэл Григорийн тооллын зөрөө энд алга. Үүний учрыг нягтлахад энд дурдсан 12 дугаар сарын 22-ны өдөр тасарч 21-ээс 23-нд шууд шилжиж буй учир өвлийн сүүл сар буюу арванхоёрдугаар сарын хорин есний өдөр нь 1913 оны хоёрдугаар сарын дөрвөнтэй таарч байна. Эдгээр гурван огноог харьцуулж үзэхэд УТА ба ГХЯ-ны архивт буй уул гэрээний хоёр эхэд буй огноо нэг өдрийн зөрүүтэй бол УТА-д буй эхэд дурдсанаар бол уул гэрээнд 1913 оны хоёрдугаар сарын дөрөвний өдөр гарын үсэг зуржээ. Хураангуйлж хэлэхэд ГХЯ-ны архивт буй эхэд буй 1913 оны нэгдүгээр сарын арван буюу арваннэгний өдөр огноо хамгийн зөв нь бололтой. Яагаад гэвээс тэрхүү эх нь албан ёсоор баталгаажуулсан тамга, гарын тийз, лацтай монгол түвэд хоёр эхийг мяндсан утсаар холбож бэхэлсэн байна. Үүнээс үзвэл энэхүү эх нь жинхэнэ эх мөн бололтой. Харин цаашид дээр өгүүлсэн гурван эхийг хооронд нь сайтар жишиж утга агуулга болон бичивэр судлалын үүднээс нарийвчлан шинжлэх нь чухал байна.

мөн түүнчлэн энэхүү гэрээний тухай судлаачид хэрхэн шинжилсэнийг ч бас улируулан нягтлах шаардлагатай учир энэ талаар хураангуй өгүүлье. Оросын дипломатч И. Я. Коростовец 1920-онд бичсэн номондоо дээрхи гэрээнд холбогдох зарим зүйл өгүүлжээ. Түүнээс үзвэл 1912 онд Агваандорж Нийслэл Хүрээнд ирж И. Я. Коростовецтой уулзахдаа Далай ламыг Түвэдийн улс төрийн удирдагч гэдгийг зөвшөөрүүлэхийн тулд Монголтой гэрээ байгуулахаар төсөл бэлтгэж тус улсын удирдагчдад танилцуулсан тухай өгүүлж байсан ба түүнээс хойш төдий л удалгүй үнэхээр Монгол Түвэдийн хооронд нилээд чамбай хэлэлцээрт гарын үсэг зурсныг би олж сонссон (Коростовец 292) гэжээ. И. Я. Коростовец энэхүү гэрээ байгуулсныг мэдмэгцээ Оросын ГЯЯ-ны сайд С. Д. Сазоновт яралтай цахилгаан утас илгээж "аль аль тал нь бүрэн эрх эдлэх хүчин чадал төгс бус болохоор Монгол Түвэдийн хэлэлцээр нь улс төрийн ач холбогдлыг олж олон улсын гэрээ бичгийн нэр хүлээж чадахгүй" (Пунцагноров 59) гэжээ. Өөрөөр хэлбэл тэрбээр уул гэрээг хэрэгжүүлэх боломжгүй хэмээн үзэж байгаагаар илэрхийлжээ. Үүнийг эргэцүүлбэл Хаант Орос Монгол Түвэдийн гэрээг бүр эхнээс нь анхаарч байсан бололтой. Гэвч энэ талаар тусгасан зохиол байдгийг бид энэ удаа тодруулж амжсангүй.

Харин Далай ламын зөвлөх асан Ч. Бэлл ба ДИУ-ын зөвлөх асан Ж. Е. Моррисон нар энэ гэрээний талаар зарим зүйл бичсэнийг проф. Тайван, судлаач Д. Мөнх-Очир нарын бүтээлд тэмдэглэсэн тул энд үл өгүүлэн өгүүлэх нь 1934 оны орчмоос манай түүхчид энэ гэрээний тухай хөндөж эхэлсэн бололтой. Жишээлбэл Л. Дэндэвийн тухай өмнө нь дурдсан

бөгөөд 1955 онд эрдэмтэн Ц. Пунцагноров" Богд гэгээний Засгийн Газраас гадаад бодлогын талаар олж авсан ганцхан "амжилт" нь 1913 оны нэгдүгээр сарын арваннэгний өдөр тусгаар тогтнолоо харилцан зөвшөөрөлцөж туслалцах тухай Түвэдтэй байгуусан гэрээ болно... эхэ гэрээ нь зөвхөн монгол улсын засаг төрийн тэргүүн болсон халх монгол дахь ламын сүм хийдийн толгойлогч Богд гэгээний нэр алдрыг бэхжүүлэх талаар ач холбогдолтой байснаас өөр ямар ч ач холбогдолгүй байв" (Пунцагноров 58) гэжээ. Гэвч чухамдаа бол уул гэрээний гол учир холбогдол нь Монголын тусгаар тогтнолыг Түвэд улс бусдаас түрүүнд албан ёсоор хүлэн зөвшөөрсөнд оршиж байлаа. Гэтэл Жибзундамбын улс төрийн бодлого үйл ажиллагаанд ямагт үгүйсгэх буюу сөрөг байр сууринаас хандах ёстой байсан тухайн цагийн чанд шаардлагыг сөрөх боломжгүйн улмаас түүхч Ц. Пунцагноров дээрхи дүгнэлт хийсэн буй за.

харин түүхч Ш. Сандаг 1968 онд БНМАУ-ын түүх зохиолын дэд ботид энэхүү гэрээ бол" бага буурай ард түмний зүгээс алив колоничлолын дэглэмийг эсэргүүцсэн баримт бичиг мөн" (БНМАУ-ын түүх... 478) гэж зөвөөр тодорхойлжээ. 2003 онд хэвлэсэн "Монгол улсын түүх" зохиолын тавдугаар боть болон доктор проф Л. Жамсран, Ж. Урангуа нар 1992, 2003, 2006 онд хэвлүүлсэн бүтээлдээ дээрхи гэрээний тухай товч өгүүлжээ. Мөн түүнчлэн 2006 онд судлаач Д. Мөнх- Очир Ю. Болдбаатар нар 1913 оны Монгол Түвэдийн " гэрээ хоёр улсын албан ёсны гэрээ байсан уу эсвэл төсөл төдий зүйл байсан уу гэдэг нь... маргаантай байдаг" (Мөнх- Очир 107) хэмээн эргэлзэж байгаагийнхаа учрыг дээр өгүүлсэн Ч. Бэллийн нэгэн номонд " Далай лам өөрөө ийм гэрээ байгуулаагүй гэж" (мөн тэнд) ярьж байсан хэмээн бичсэнд тулгуурлан тайлбарлажээ. Өргэдэй Тайван " сүүлийн үеийн... зарим номд ийм гэрээ гэгч байхгүй худал зүйл юм гэж бичигдсэн удаа буй." (Тайван 71) Тухайлбал Бэлл " Түвэдийн эрт ба эдүгээ гэдэг бүтээлдээ Далай лам Монгол Түвэдийн гэрээ байгуулахыг зөвшөөрөөгүй юм гэжээ" хэмээн тэмдэглээд "маш чанартай сайн эмхтгэлүүд сүүлийн үед Бээжин ба Харбин зэрэг газраар (газарт) хэвлэгдэж байсан... гэвч эдгээр эмхтгэлд Монгол Түвэдийн гэрээнд холбогдох бичиг баримт ер харагдахгүй байх нь бас ч сонин юм" (Тайван 72) гэжээ. Мөн 1982 онд А. Очир нарын хэвлүүлсэн баримт бичгийн эмхтгэл болон МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулиас эрхлэн хэвлүүлсэн "Монголын дипломат гэрээ бичгийн дурсгал III. 1913 оны Монгол Түвэдийн найрамдлын гэрээ" зэрэг нь "яг тэр гарын үсэг зурсан баримт бичиг биш харин... эх нооргийн шинжтэй байгаа юм." Иймээс эдгээрийг уул "гэрээний монгол эхийн текстийн баримт хэмээн үзэж болохгүй" (Тайван 72-73) гэж эргэлзсэн нь зүйтэй юм. Өргэдэй Тайван хэдийгээр уул гэрээний жинхэнэ эхийг үзээгүй боловч Японоос Орост сууж байсан консул Тазеке Шичита 1913 оны нэгдүгээр сарын 17. хоёрдугаар сарын 15-нд Токио руу илгээсэн цахилгаан утас, албан бичигт болон Бээжин, Харбинд сууж байсан Японы консулуудаас мөн оны хоёрдугаар сарын 6-нд Бээжинд сууж байсан консул Ижиоян Хикохичиас Токиод бичиг чахилгаан илгээж дээрхи гэрээний тухай мэдэгдсэн хэд хэдэн сурвалжийг Японы архиваас олж судлаад Монгол Түвэдийн гэрээг 1913 оны хоёрдугаар сарын 4-нд биш нэгдүгээр сарын 10-нд байгуулсан нь эргэлзээгүй юм байна гэсэн дүгнэлт хийжээ.

Үүнээс гадна Японы консул Тазеке Шичита уул гэрээ нь " Далай ламын улс төрийн байр суурийг сэргээсэн байна. Энэ гэрээг Монгол ба Түвэдэд холбогдох хэмжээт эзэрхийллийн дэглэмийг эсэргүүцсэн ил тодорхой гэрч гэж үзэж болох юм" (Тайван 75) хэмээн онцлон дурдсаныг Өргэдэй Тайван эш татаж оруулжээ. Бээжингээс консул Ижиоян Хикохичи Токио руу уламжлахдаа " Далай ламаас Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрсөн нь монголчуудад хамгийн их өнгө гэрэл болсон бөгөөд Түвэдийн хувьд авч хэлбэл энэ гэрээ нь тэд нэгэнт тусгаар тогтносон гэдгийг тунхагласан хэрэг болно гэж үзэцгээж байна" (Тайван 75) хэмээсэн нь тэр үед Японы дипломатууд Монгол Түвэд хоёр

улс харилцан тусгаар тогтнолоо албан ёсоор зөвшөөрлөө гэж ойлгосны нотолгоо болж байна.Гэвч Англи улс уул гэрээг хэрхэн үзэж байсан тухай проф. айван өгүүлэхдээ" хамгийн анх Англи улс хөндлөнгөөс нь оролцож энэ гэрээг цуцалж баллах оролдлого хийсэн байна."(Тайван 71) Тухайбал" Английн парламентаас Монгол Түвдийн гэрээг үл зөвшөөрөх хэргийг илэрхийлж байлаа...тэрчлэн гадны бусад гүрнүүд ч тус гэрээг хүлээн зөвшөөрөхгүй байсан." Энэ бол " бага буурай орнуудыг нөлөөнийхөө хүрээнд оруулж тэднийг бие дааж тусгаарлах чадлыг нь үгүйсгэж байсантай холбоотой юм"(Тайван 72) гэж онцлон тэмдэглэжээ .

Ийнхүү Зохиогч Монгол Түвэдийн Гэрээ бол бодитой зүйл гэдгийг Японы архивын баримтад түшиглэн нотлож зохих дүгнэлт хийсэн нь 1911 онд тусгаар тогтнолоо сэргээсэн Монгол Улсын төрийн гадаад бодлогыг нэхэн шинжлэхэд зохих тус дөхөм үзүүлж буйг талархан тэмдэглэж байна.

ГУРАВ. 1913 оны Өвөр Монголын байлдаан буюу Үхэр жилийн үймээний тухай

Проф. Тайван энэ номынхоо багагуй хэсгийг (195-328 дэх тал) Монгол,Хятад цэргийн байлдааны тухай асуудалд зориулсан байна.

Түүх судлаач олон хун энэ сэдвийг сүүлийн 80 гаруй жил хөндөж янз бүрийн байр сууринаас тайлбарлаж байна. Манай Түүх бичлэгт 1920-иод таван удаа хэвлэсэн БНМАУ-ын түүх,Монгол улсын түүх зохиолд дурдсан байдаг. Мөн зарим түүхчид Монголоос Өвөр Монголын нутагт орж хятад цэрэгтэй дайтсан тухай зохиол бүтээлдээ цухас өгүүлж байв. Тухайлбал түүхч.Ц.Пунцагноров 1955 онд хэвлүүлсэн бүтээлдээ дээрхи дайны эхлэлийг 1912 оны зун Юан Ши кай Өвөр Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дарах болсон учир мөн оны " намраас эхлэн" Өвөр Монголд" хятад монгол цэргүүд уе уе тулалдаж эхлэв"(Пунцагноров59) гэж бичсэн боловч үүнийгээ чухам ямар сурвалжид тулгуурласнаа дурдсангүй. Гэхдээ энэ бол монгол, хятад цэргийн анхны байлдаан 1912 оны намар эхэлсэн гэж тодорхой хугацаа зааснаараа судлаачдын анхаарлыг татаж байгаа юм. Гэтэл үүнийг түүхчид төдий л анзаараагүй өнгөрсөн билээ.Сайтар эрэгцүүлбэл түүхч Ц. Пунцагноровын зохиолд дурдсан цаг хугацааг сурвалжаар нотлох шаардлагатай мэт.Миний бодоход Халх буюу Гадаад монголын цэрэг 1912 оны намар Өвөр Монголын нутагт хараахан орж амжаагүй баймаар. Харин өвөрлөгчид сайн дураараа цэрэг элсээж өөрсдийн амь нас, газар нутаг,өмч хөрөнгөө хамгаалахын тулд арга буюу хятад цэрэгтэй дайтаж эхэлсэн бололтой.

Дээр дурдсан зүйлдээ тулгуурлан өгүүлэхэд Өвөр Монголын эрх чөлөөний төлөө тэмцэл хөдөлгөөнийг ДИУ хүчээр зогсоох хэмжээ эсэргүүцсэний улмаас Монгол,Хятад цэргийн байлдаан чухам хэзээ эхэлсэнийг болон Монгол, ДИУ аль аль нь түүнд хэрхэн бэлтгэсэн , чухам хэзээ, хаана, ямар тулалдаанууд болсон зэргийг нэхэн тодруулах нь түүхчдийн зайлшгүй судлах сэдэв болж байгаа юм.Тиймээс ч сүүлийн үед энэ асуудлын түүхч Е.А.Белов болон залуу судлаач Б.Батсүрэн нар нилээд ултай шинжлэхийг хичээж байгаа нь нэн сайшаалтай, Харин 1996 онд Монгол Улсын Батлан Хамгаалах Яамны эрдэм шинжилгээний хүрээлэнгээс эрхлэн боловсруулсан "Монгол цэргийн түүхийн товчоон" зохиолын дэд дэвтэрт энэ сэдвийг хөндсөн боловч шинэ зүйл хомсхон байгаа нь янз янзын шалтгаантай буйза.

Ингээд дээр өгүүлж байсан асуудлаа үргэлжлүүлье.Өргэдэй Тайван1912 оны сүүлийн хагасаас монгол цэрэг ДИУ- ын" цэргийн хоорондох зэвсэгт мөргөлдөөн" эхэлсэн байна. Гэхдээ хамрах хүрээ нь их бус байв(Тайван 146)гэжээ.Энэ нь1955 нд Ц.П унцагноов түүхчийн бүтээлд дурдсан хугацаатай үндсэндээ тохирч буй юм. Гэвч,Өргэдэй Тайван энэ хугацаанд болж байсан зэвсэгт ажиллагаань хоёр этгээдгийн төр засагийн удирдлага доор

явагдаж байсан явдал биш гэснийг зааж гаргажээ.

Монгол, ДИУ-ын хооронд зэвсэгт мөргөлдөөн гарч болзошгүй байдал бий болсныг Хаант Орос улс хэрхэн үзэж байсан бэ гэдгийг Зохиогч сурвалжид тулгуурлан өгүүлэхдээ ДИУ-ын Засгийн газар Монгол руу дайтах тухай 1912 оны дөрөвдүгээр сард хэлэлцсэн ба энэ мэдээг Оросын эрх баригчид сонсоод ДИУ Монгол руу зэвсэглэн халдвал манай улс зүгээр харж суухгүй шүү хэмээн анхааруулж байсныг дурджээ. Мөн 1912 оны дөрөвдүгээр сарын 22-нд Цицикарт сууж байсан Оросын консул Афанасьев Оросын Гадаад Яамны сайд С. Д. Сазоновт энэ тухай мэдээлсэн ба үүнээс гурав хоногийн дараа Бээжинд сууж байсан элчин сайд Н. В. Крупенский ДИУ-ын Гадаад Харилцааны ерөнхий дарга Лу Жен сиянтай ярилцаж ДИУ-ын хөдөлгөөнийг дарангуйлах явдал бол Орос, ДИУ-ын зэвсэгт хүчин "Хөлөн Бойрын алинд нь ч ашиггүй сөргөлдөөн үүсгэх болно гэдгийг Юань Ши кай-д заавал мэдэгдэх хэрэгтэй гэжээ" (Тайван 166-167) гэж анхааруулжээ. Тэр үед Хаант Орос "Өвөр Монголын хөдөлгөөнийг дэмжихгүй, гэхдээ хэрэв хэрэг явдал даамжирч зэвсэгт хүчнээр манай анхаарч байгаа газар орны хөдөлгөөнийг дарангуйлах хэмжээнд хүрвэл бид лавтайя хайхрахгүй байж болохгүй учир нь энэ нь манай улсын ашиг тусад халдаж байх явдал болно" (Тайван 167) гэж мэдэгдсэн байжээ.

Ийнхүү Монгол, ДИУ-ын хооронд дайн үүсэж болзошгүй байдлыг Хаант Орос ихээхэн анхаарч харилцан ойлголцоосой хэмээсэн байр суурьтай байжээ гэж ойлгохоор проф. Тайван бичжээ. Гэхдээ чухам ягаад Хаант Орос ийм бодлого баримтлах болсныг зохиолд тогтож тайлбарлаагүй зөвхөн "Оросын засгийн газараас өвөр Монголын асуудал дээр Богд хааны засгийн газарыг дэмжихгүй байсан нэг шалтгаан нь, 1910 он ба 1912 онд байгуулагдсан Орос, Японы нууц гэрээнд Ар Монголыг Орос-ын, Өвөр Монголыг Японы хүчний хүрээ болгохоор хоёр талаараа тохиролцсон зүйлийг фос эрхбиш журамлах хэрэгтэй бөгөөд Бээжингийн засгийн газартай харилцаагаа ч харгалзахгүй байхын аргагүй" (Тайван 298-299) хэмээн тухайн үеийн Фосын байр суурьд холбогдох нэг шалтгааныг тайлбарласан байна. Ахиад энэ тухай Бидний бодоход тухайн үед ДИУ Өвөр Монгол, Гадаад Монголын аль алиныг цэргийн хүчээр өөртөө нэгтгэх буюу автономит эрхтэйгээр захирах боломж бүрдүүлбэл хаант Орост ихээхэн хохирол учрах нь мэдээж байлаа. Тиймээс ч Гадаад Монгол, ДИУ-ын сөргөлдөөнийг намжаахаар хичээж байсан нь мэдээж. Зохиогч энэхүү бүтээлдээ Хятад, Японы янз бүрийн архиваас нилээд баримт илрүүлж судалгааны эргэлтэд анх удаа оруулсан нь сонирхол татаж байна. Жэцэлбэл, ДИУ-аас Монгол руу дайтахаар зургаан хэсэг газар цэрэг байршуулж үлэмж зэвсгээр хангажээ. Үүнд:

1. Өвөр Монголын баруун этгээд буюу Хөх хотын чиглэлд байлдах бүх цэрэг 7490, үүнээс явган цэрэг 5860, морьт цэрэг 1400, Хөх хотын буут цэрэг 230, их буу 15, пулемёт 6.

2. Чуулалт хаалгын чиглэлд байлдах бүх цэрэг 7310, үүнээс явган цэрэг 4120, морьт цэрэг 2470, буут цэрэг 400, их буу 24, барилгын цэрэг 220, пулемёт 22, хүнд хөнгөн цэрэг 100.

3. Өвөр Монголын дунд хэсгээр буюу Халуун голын чиглэлд бүх цэрэг 9700, үүнээс бүх цэрэг 7720, морьт цэрэг 1650, буут цэрэг 230 их буу 14, инженерийн цэрэг 100, пулемёт 12.

4. Өвөр Монголын дунд зүүн өмнө хэсэг ба Кайлу-гийн чиглэлд бүх цэрэг 6180, үүнээс явган цэрэг 4340, морьт цэрэг 1590, буут цэрэг 250, их буу 27, пулемёт 24.

5. Өвөр Монголын зүүн хэсэг буюу Шаазгай хотын чиглэлд бүх цэрэг 2600, үүнээс явган цэрэг 1600, морьт цэрэг 900, буут цэрэг 100, их буу 6.

6. Өвөр Монголын зүүн хойт хэсэг буюу Манжуур, Хайлар, Цицикарын чиглэлд төмөр зам

хамгаалах цэргийн анги, явган цэргийн зургаан холбоот анги, морьт цэргийн зургаан холбоот анги, буут цэргийн дөрвөн дундад анги, барилгын цэргийн дундад анги 1, төмөр замын цэргийн дундад анги 64, нийт цэргийн тоо 33460, их буу 85, пулемёт 54- г бэлтгэсэн байв.

Мөн, зарим судлаачдын бүтээлд Монголыг дайлах цэргийн тоо 39900 гаруй, их буу 54, пулемёт 48 гэж дурдсан байдаг ажээ. Эдгээр цэрэг бүгд байлдаанд оролцсон эсэх талаар тодорхой дурдаагүй байна.

ДИУ- с Монгол улсын тусгаар тогтнолд эрс дургүйцэж байгааг ухаарсан Монголын Засгийн Газар нутаг дэвсгэрээ хамгаалах талаар тодорхой дэс дараатай бодлогыг 1912 оноос хэрэгжүүлж эхэлсэнийг Өргэдэй Тайван тодорхой дурджээ. Тухайлбал, 1912 онд Монголын Засгийн Газар баруун ба өмнө хязгаар Дарьганга, Егүзэрийн хийд 1913 оны эхээр Сөнид, Улаан-Цавын чиглэл, бусад чуулганы зүг илгээсэн байна. (Тайван 262). Гэвч " Юань Ши кайн Засгийн Газар Монголын тусгаар тогтнолыг үл зөвшөөрөн цэргийн хүчээр багалзуурдан дарах"(Тайван 263) зорилгоор 1912 оны сүүлчээр Бат Хаалга, Долон нуур, Халуун гол зэрэг хотуудад их цэрэг байршуулж улмаар Шар сүм, Хөх хотын чиглэлд цэргийн отрядууд байрлуулсан төдийгүй мөн оны суулчээр Бээжингээс 15 мод зайтай орших Цагдуулт гэдэг газраас мордуулсан хятад цэрэг Монголын баруун хязгаарын цагаан Түхгэд очиж өвөлжөөд бүх бэлтгэлээ ханган 1913 оны зургадугаар сарын нэгэнд Цагаан Түнгийн Улаан хайханд байсан монгол цэрэг рүү довтолход хоёр талаас 22 хүн амь үрэгдэж, 30 хүн шархдаж мөн сарын долоонд уул газар дахин 2 удаа тулалдахад Монголоос 700 гаруй, Хятадаас 2000 орчим цэрэг оролцож Хятадын талаас 20 орчим цэрэг алагдаж 50 морь олзлуулсан байна. Гэвч тэндэх мөргөлдөөн мөн оны долоодугаар сарын 14-нд дахин сэргэжээ. Ийнхүү байдал хүндэрсэнд Хаант Орос Дээд-Үдээс Нийслэл Хүрээгээр дамжуулан Ховд руу Хасаг цэргийн анги, мөн Бийскээс 3000 хүнтэй явган цэрэг их бууны ангийг Ховдод очуулсан бөгөөд ингэснээр ДИУ- аас" Монголыг байлдан эзлэх хэмээн санаархахыг зогсоожээ"(Тайван 264) гэж тэмдэглэжээ. Өргэдэй Тайвангийн энд өгүүлсэн баримт бол урьд өмнө нь манай түүхчдийн судалгаанд өртөөгүй шинэлэг бөгөөд 1911 оноос хойш Орос, ДИУ хоёр Монголын тухайд ямар байр суурьтай байсныг тодруулахад чухал учир холбогдолтой юм.

ДИУ- ын цэрэг Ховд Хязгаараас буцсаны дараа" Бээжингийн Засгийн Газар" монголчуудын нэгдэх хөдөлгөөнийг таслан зогсоохын тулд цэргийн хүчээр залхаан цээрлүүлэхээр шийдэж... таван замаар их цэрэг оруулж Өвөр Монголын ард түмнийг хайр найргүй хядан хатуу ширүүнээр дарлан зовоож Халх Монголд заналхийлэх боллоо(Тайван 364) гэж тухайн үед ДИУ-аас Монголын тухайд дэс дараа бүхий бодлого хэрэгжүүлж байсныг тодорхой өгуулжээ.

Энэхүү зохиолд анхаарал татахуйц шинэ, сонин мэдээ цөөнгүй байгаагийн нэг жишээ бол 1913 онд Ж. Дамдинсүрэнгийн удирдсан цэрэгт Д. Лосолыг цэргийн ламаар томилж явуулсан бөгөөд тэрбээр" цэргийн сэтгэл санааг ариусгах ном уншиж явсан учир цорж ямба шагнуулж байжээ."(Тайван 268)

Өвөр Монголын нутагт 1913 онд хэдэн сарын турш үргэлжилсэн монгол, хятад цэргийн байлдааны тухай дэлхий дахин анхаарч янз бүрийн мэдээлэл Орос, Англи, Японы хэвлэлд хийтээгдэж байсныг энэ зохиолд эш татан өгүүлсэн байна. Монгол цэрэг Өвөр Монголын нутагт орсон чухам учир шалтгаанг проф. Тайван дүгнэж бичихдээ" монголын цэрэг нь Иргэн Улсын хүчнээс Өвөр Монголын нутгийг хамгаалах зорилготой байлаа. Ийм ч учраас Богд хааны Засгийн Газар нь Өвөр Монголын эзлэх асуудлыг улс орны бүрэн бүтэн

байдгийг(байдлыг) хамгаалах ба тусгаар тогтнолоо бататгах үүднээс үүсэж иргэн улсын газар нутагт өчүүхэн ч халдахгүй байхыг бүх цэрэг тушмэддээ чандлан тушааж бусдын нутгийн тэмцэхгүйг дахинтаа(олонтаа) чандлан анхааруулсан билээ"(Тайван 277). Энэ нь тухайн үед манай улсын Засгийн Газар тууштай баримталж байсан бодлогыг онож тодорхойлсон дүгнэлт юм.

Монголын цэрэг 1913 оны эхний хагас жилд хятад цэргийг байнга давамгайлж байсан боловч суулдээ зэвсгээр гачигдсаны улмаас ДИУ-ын цэрэгтэй үргэлжлэн дайтахад бэрхшээлтэй болсон шалтгааныг Өргэдэй Тайван тайлбарлажээ. Тэр үед ДИУ-ын дотоод байдал хурцадаж" иргэний дайн үргэлжилж Юань Ши кайн харгис дэглэмийн эсрэг бослого гарч бүх дэвшилт хүчин эсэргүүцэн тэмцэж байсан учраас энэхүү тэмцлийг дарахад Бээжингийн Засгийн Газар хамаг хүчээ дайчилж байв." Үүний улмаас" Юань Ши кайн Өвөр Монголд үлэмж цэрэг явуулж Богд хаант Монгол улсын эсрэг түрэмгийлэл хийх бололцоогүй болжээ"(Тайван 280) гэж бичсэнийг үгүйсгэх аргагүй боловч эргэлзээтэй мэт. Тодруулж хэлбэл ДИУ Өвөр Монголыг бусдад алдчихгүйн тулд ихээхэн анхаарч байсан нь маргаангүй билээ.

Өвөр Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдлгөөнийг дарахад ДИУ-аас гадна Хаант Орос, Японы аль нь сонирхолтой байсныг Өргэдэй Тайван тэмдэглээд үүнийхээ нотолгоо болгож" хоёрдугаар Николай Засгийн Газар нь Өвөр Монголд туслахаар Халхаас цэрэг оруулахыг монголын империализм гэж үзэн хориглож байсан юм"(Тайван 280) хэмээн өгүүлжээ. Өвөр Монголд монгол, хятад цэрэг байлдаж байх үед Бээжинд Хаант Орос, ДИУ-ын төлөлөгчид Монголын тухай асуудлыг хэлэгцэж санал тохирохгүйн улмаас удтал маргасаар эцэст нь" Орос улс Дундад улсын Ар Монголыг хэмжээтэй эзэрхэхийг зөвшөөрөн хүлээх"," Орос улс, Дундад улс хоёр монголд өөрсдийнхөө цэрэг ба нүүдлийн иргэдийг оруулан суурьшуулахгүй байх үүргийг харилцан хүлээх"(Тайван 283) гэж тэмдэглэсэн байна.

Ингэж Хаант Орос, ДИУ хоёр Монголын тухай харилцан ашигтай тохиролцоонд хүрснийхээ дараа Монгол Улсыг өөрийнхөө цэргийг Өвөр Монголоос нэн даруй буцааж тат хэмээн сүрдүүлсээр санасандаа хүрсэн билээ. Монголын Засгийн Газар" цэргээ хэдий гэдрэг татсан боловч улс орноо нэгтгэх санаагаа орхиогүй түүнийгээ гагцхүү цэргийн хүчээр бус дипломат аргаар гүйцэтгэхийг зорьжээ"(Тайван 288) хэмээн онцлон тэмдэглэжээ.

Өргэдэй Тайвангийн энэхүү бүтээлд дээр өгүүлсэн гурван зүйлээс гадна хэн хүний сонирхол татахуйц шинэ сэргэг баримт бичиг, фото, өлгөц тайлбар олон байгааг уншигч аругай Та толилох буй за.

Эцэст нь тэмдэглэхэд акад. Ш. Бира аругай" Шинжлэх ухаан гэдэг бол ерөөсөө баримт мэдээнд тулгуурладаг. Тиймээс юу юу ч эхлээгүй байхад онолдоод өөрийн санаагаар хий хоосон зүтгээд байх биш баримтаа олох", " мухайн үеийн үзэл суртал, улс төрийн зорилгод нийцүүлэхийг бодохгүй байх","хүнд таалагдах гэж эрдэм шинжилгээний ажил хийх хэрэггүй"(Ш. Бира № 256(1994)) хэмээн судалгааны ажилд хэн боловч чанд баримтлах гурван зарчмыг онож тодорхойлсныг Доктор Өргэдэй Тайван жинхэнэ байдлаар хэрэгжүүлжээ хэмээн энэхүү товч шүүмжийг тэрлэгч би үзэж байна.

Ном зүй

1. Бира Ш. Шинжлэх ухаан төрийн багш нь биш гэхэд зөвлөх нь байгаасай," Өнөөдөр" сонин 2003-11-01 №256(1994).

2. БНМАУ-ын түүх, Дэд боть 1604-1917, УБ.1968.
3. Бямбажаргал Л. Цовоохүү Ч. Билиг аргын тоолол(XV.XVI.XVII жаран)(1867-2046), УБ.2004.
4. Коростовец И. Я. От Чингис хана до Советской Республики Краткая история Монголий с особым учетом новейшего времени ,УБ.2004.
5. Магсаржав Н. Монгол улсын шинэ түүх, УБ.1996.
6. Мөнх-Очир Д. Болдбаатар Ю. Олноо өргөгдсөн Монгол улсын статус-1911 оны үндэсний хувьсгал ба Богд Жибзундамба хутагт Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл ,УБ. 2007.
7. Пунцагноров ц. Монголын автономит үеийн түүх ,УБ.1955.
8. Тайван Ө. Үхэр жилийн үймээний гэрэл ба сүүдэр, ӨМСХХ, Хөх хот, 2006.
9. Цыбульский В.В. Лунно-солнечный календарь стран Восточной Азии, М. 1987.